



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

додо оны 09 сарын 08 өдөр

Дугаар 434

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 455,804,587.24 (дөрвөн зуун тавин таван сая найман зуун дөрвөн мянга таван зуун наян долоон төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 3 (гурав) ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.”Эрдэнэт үйлдвэр”төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2020 оны 400 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

900319

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 09 дугаар...сарын 28 өдрийн  
434 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

№	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ		Худалдах доод үнэ
			Нэг бүрийн үнэ	НИЙТ ҮНЭ, ХУРИМТЛАГДС АН ЭЛЭГДЭЛ	
			/Төгрөг/		
1	Газель, 3927 OPX арал 270500-70346989	2008	156,896,879.50	156,896,879.50	1,500,000.00
2	Чирэгч татара-815 6015 OPX арал TNT815VN8KK096678	2008	221,826,423.56	221,826,423.56	10,000,000.00
3	Зил-433362, АТ3-7, 3921 OPX, арал 43336283497515	2008	77,081,284.18	77,081,284.18	3,750,000.00
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>455,804,587.24</b>	<b>13,750,000.00</b>
			(дөрвөн зуун тавин таван сая найман зуун дөрвөн мянга таван зуун наян долоон төгрөг хорин дөрвөн мөнгө)		(арван гурван сая долоон зуун тавин мянга)